



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн захиалгыг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

АУДИТЫН НЭР:

Авто Замын сангийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг

АУДИТЫН КОД: УАГ-БНАТАГ-/2018/02-ГА



**Баянхонгор хот
2018.05.15**

Тайланг бэлтгэсэн:

**Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор**

Аудитын менежер

**Аудитор
Аудитор**

2018 оны 05-р сарын 03

**Тайланг:Аймгийн аудитын
газрын**

Цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.bayankhongor.mn

**Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70442584,
70442424 дугаарын утсаар
харилцана уу.**

**ХАЯГ: Үндэсний аудитын
газрын харьяа Баянхонгор
аймаг дахьТөрийн аудитын
газар**

АГУУЛГА

Бүлэг-1. Авто замын санд төвлөрөх хөрөнгийг

бодитой тооцож төлөвлөн, бүрэн бүрдүүлсэн эсэх

Бүлэг 2. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх

төсөл, арга хэмжээг холбогдох хууль журмын дагуу

баталж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх

Бүлэг-3. Төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх

ТОВЧИЛСОН ҮГИЙН

ЖАГСААЛТ.....3

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН.....4-5

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН.....6

1. Авто замын санд төвлөрөх орлогыг
үндэслэлгүй төлөвлөж бүрдүүлжээ.2-8

2. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх
төсөл арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөж,
холбогдох хууль журмын дагуу баталсан ч
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг
хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.9-13

3.Сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим төсөл
арга хэмжээний үр дүн хангалтгүй
байна.....14-21

АУДИТЫН

ДҮГНЭЛТ22

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГА	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
АЗДТГ	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
АТБӨЯХАТ	АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР
ТБОНӨХБАУХАТХ	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ
ХОХБТХ	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС
СТСХ	САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС
АТТ	АВТО ТЭЭВРИЙН ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

1.Аудитын нэр: Авто замын сангийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг

2.Аудитын код: УАГ-БНАТАГ-/2018/-02-ГА

3.Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 1а/398 тоот албан бичгээр ирүүлсэн аудит хийлгэх захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 19.1 дүгээр зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

4.Аудитын зорилтууд:

Авто замын сангийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашигт аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийв.Үүнд:

- Авто замын санд төвлөрөх хөрөнгийг бодитой тооцож төлөвлөн, бүрэн бүрдүүлсэн эсэх
- Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу баталж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх
- Төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн эсэх

5.Аудитын хамарсан хүрээ:

Аудитад авто замын сангийн хөрөнгөөр 2017 онд батлагдан хэрэгжсэн төсөл арга хэмжээг хамруулан аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Баянхонгор аймгийн Авто тээврийн төв зэрэг байгууллагуудаас шаардлагатай санхүүгийн баримт, ИТХ-ын тогтоол, мэдээ, тайлан, судалгаа бусад материалд тулгуурлан гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

6. Үндсэн мэдээлэл:

Баянхонгор аймагт 2017 онд АТӨЯХАТ-аар 428,7 сая, авто зам ашигласны хураамжаас 116,1 сая, урьд оны үлдэгдлээс 21,2 сая, нийт 566,0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймгийн ИТХ-аар анх 16 төсөл арга хэмжээнд 345,6 сая төгрөгийг баталж, тайлант хугацаанд 3 удаа тодотгож, нийт 25 төсөл арга хэмжээнд 551,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төсвийг баталж, тайлант онд АТӨЯХАТ-аар 399,6 сая, авто зам ашигласны хураамжийн орлогоор 117,5 сая төгрөг, нийт 517,1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, аймгийн Авто замын санд 380,0 сая төгрөгийг

төвлөрүүлж, нийт 25 төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 475,3 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

7.Эрсдэлийн үнэлгээ

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг "дунд" гэж үнэлэв.

8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжийн хүрээнд аймгийн ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, Татварын хэлтэс, МХГ, ГХБХБГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

9. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
 - Барилгын тухай хууль
 - Автозамын тухай хууль
 - Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”
 - Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам.
 - Сангийн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 47/81 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Орон нутгийн замын сангийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэх, хянаж, санхүүжүүлэх журам”
 - Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”
 - Холбогдох бусад эрхийн актууд.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

Авто замын сангийн дансанд 2017 оны эхэнд 21.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд АТБӨЯХАТатвараар орсон 399.6 сая төгрөгийн орлогоос 380.0 сая

төгрөгийг, авто замын хураамжаас 117.5 сая төгрөг, нийт 497.5 сая төгрөг төвлөрүүлж, 475.3 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 43.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. АТБӨЯХАТатварын үлдэгдэл 19.6 сая төгрөг аймгийн Ерөнхий орлогын дансанд үлджээ.

1. Авто замын санд төвлөрөх орлогыг үндэслэлгүй төлөвлөж бүрдүүлжээ.

1.1. Авто замын санд төвлөрүүлэх орлогыг аймагт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо үнэн зөв гардаггүйгээс урьд онуудын гүйцэтгэлд үндэслэж төлөвлөсөн байна.

Автотээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэхийг Баянхонгор аймгийн Авто тээврийн газраас ирүүлсэн авто тээврийн хэрэгслийн тоог аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төлөвлөсөн тоог харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.



Аймгийн засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/248 дугаар захирамжийн дагуу аймгийн хэмжээнд сүүлийн 4-5 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, АТБӨЯХ-ийн албан татвар төлөөгүй, бүртгэлийн сангаас хасагдах 2500 тээврийн хэрэгслийн судалгааг гаргаж, 618 тээврийн хэрэгслийн материалыг бүрдүүлж, Авто тээврийн төвийн мэдээллийн баазаас хасуулсан байна.

Авто тээврийн газраас ирүүлсэн нийт бүртгэлтэй авто машины судалгаанд үндэслэн дээрх 2500 тээврийн хэрэгслийг хувь тэнцүүлэн хасч, мөн бүртгэлтэй 4761 мотоциклоос 2017 онд 838 ширхэг мотоцикл үзлэгээр орсон ба зөрүү 3957 мотоциклоос 3500 мотоцикл хасч /Энэ нь мотоциклийг үзлэгээр оруулахгүй ихээр задалж сэлбэгэнд хэрэглэдэгтэй холбоотой/ тооцоо хийж үзэхэд аймгийн хэмжээнд нийт 14877 тээврийн хэрэгсэл татвар төлөхөөр байгаа бөгөөд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 46 дугаар тогтоолоор баталсан татварын хувь хэмжээний интервалын хамгийн бага утгаар орлогыг тооцоход 566.7 сая төгрөг төвлөрөх боломжтой байна. Энэ нь аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төлөвлөж байгаагаас 4881 тээврийн хэрэгслээр буюу 138.0 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь АБӨЯХ-ийн татвараар орох орлогыг тээврийн хэрэгслийн бодит тоонд уялдуулаагүй төлөвлөжээ.

Мөн авто зам ашигласны төлбөрийн хураамжийн хэмжээг аймгийн Засаг даргын 2014 оны 671 тоот захирамжаар тогтоосон байна. Санхүү төрийн сангийн хэлтэс нь авто зам ашигласны хураамжийн орлогыг төлөвлөхдөө тогтоолд заасан ангиллаар бодит тоо, болон тарифаар төлөвлөдөггүй, өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон авч төлөвлөж байна.

№	Тээврийн хэрэгсэлийн төрөл	Ногдуулах хураамж /төгрөгөөр/	Зам ашигласны хураамж	
			Тээврийн хэрэгсэлийн тоо	Орлогын дүн /мян.төг/
1	Мотоцикл	2000	1261	2,522.0
2	Суудлын авто машин	10000	8361	83,610.0
3	Микроавтобус /10 хүртэл хүний суудалтай/	30000	1006	30,180.0
4	Автобус	40000	64	2,560.0
5	Ачааны машин 3.5 тн хүртэл	20000	3240	64,800.0
	Ачааны машин 3.5-12 тн хүртэл	45000	447	20,115.0
	Ачааны машин 12 тн -с дээш	60000	52	3,120.0
6	Механизм	50000	77	3,850.0
7	Тусгай зориулалтын автомашин	45000	281	12,645.0
8	Чиргүүл		88	-
			14877	223,402.0

Авто тээврийн газраас ирүүлсэн судалгааг үндэслэн дээрх захирамжаар батлагдсан тарифаар авто зам ашигласны хураамжийг тооцож үзэхэд 223.4 сая төгрөгийн орлого төвлөрөхөөс 2017 онд 116,0 сая төгрөг орохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 117,5 сая төгрөг орсон байгаа нь 107,4 сая төгрөгийн зам

ашигласны хураамжийг бүрдүүлэх боломжтой байсан байна.

Иймд тээврийн хэрэгслийн бодит тоо бүртгэлийг аймгийн Авто тээврийн газартай тохируулж, түүнд үндэслэн төлөвлөлтийг үнэн зөв, бодитой хийгээгүй, ашиглагдахгүй байгаа тээврийн хэрэгслийг материалжуулж, бүртгэлээс хасаж үнэн зөв тоо гаргах ажлыг эрчимтэй зохион байгуулаагүй нь өмнөх онуудын аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул холбогдох байгууллагуудад үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

1.2 Тээврийн хэрэгслийн бодит тоонд үндэслэж ноогдуулалт хийгээгүй, албан татвар, хураамж авах талаар холбогдох байгууллагуудын хамтын

ажиллагаа хангалтгүйгээс 245,4 сая төгрөгийн орлого бүрдэх нөөц бололцоог алдсан байна.

Орон нутгийн авто замын сангийн эх үүсвэрийг Авто замын тухай хуулиар АТБӨЯХ-ын албан татвар, Орон нутгийн зам ашигласны төлбөр, Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, Хууль зөрчсөн этгээдэд ноогдуулсан торгууль, Зээл, тусламж, хандивын орлого, авто замын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөр гэсэн 6 эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан байна.

2017 онд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар /цаашид АТБӨЯХАТ гэх/ -аар 428,7 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс 399,6 сая төгрөг төвлөрч төлөвлөгөөг 93 хувиар биелүүлсэн ба үүнээс замын санд 380.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Татварын орлогын төлөвлөгөө биелээгүй нь 2017 оны 11 сарын 27-ны 7/01 дугаар хуралдаанаар АТБӨЯХАТ-ын орлогын төлөвлөгөөг 92,3 сая төгрөгөөр жилийн эцэст нэмж тодотгосонтой холбоотой байна. Үүнийг судалж үзэхэд аймгийн ИТХ-д нэмэлтээр өргөн барьсан тооцоо судалгаа аймгийн ЗДТГ-т байхгүй байсан бөгөөд СТСХ-ийн мэргэжилтэн Ц.Дагвадоржоос тодруулахад ИТХ-р шууд нэмж тодотгосон гэсэн тайлбарыг өгсөн болно.

Харин зам ашигласны хураамжийн орлогыг 116,1 сая төгрөгөөр төлөвлөж, 117,5 сая төгрөгөөр буюу 101,2 хувиар биелүүлж, орлогыг Замын санд төвлөрүүлжээ.

Аудитын судалгаанаас авч үзэхэд тээврийн хэрэгслийн бодит тоонд үндэслэж ноогдуулалт хийгээгүй, татварыг хураамж авах талаар холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүйгээс АТБӨЯХАТ-аар 138,0 сая, зам ашигласны хураамжаас 107,4 сая, нийт 245,4 сая төгрөгийн орлого бүрдэх нөөц бололцоог алдсан байна.

2. Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөж холбогдох хууль, журмын дагуу баталсан ч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

2.1 Төв талбайн гэрэлтүүлгийн засварын ажлаас бусад сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг хуульд нийцүүлэн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж төлөвлөсөн байна.

Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 129, 130, 131,132-р заалт, Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 114, 117,118,119-т заасан урт болон дунд хугацааны хөтөлбөр, нэгдсэн бодлого төлөвлөлтийн арга зүйн дагуу 2017 онд замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт, зарцуулах хөрөнгийн хэмжээг төлөвлөсөн байна. Мөн тайлант хугацаан дундуур Аймгийн ИТХ-аар замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад 9 төсөл арга хэмжээг нэмж тодотгосон байна.

2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 7/01 дугаар тогтоолоор 50 сая төгрөгийн өртөг бүхий Баянхонгор аймгийн Төв талбайн гэрэлтүүлгийн засварын ажлыг тодотгож оруулж өгсөн байна. Энэ нь Авто замын тухай хуулийн 24.8-д заасан “авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.” гэсэн заалттай зөрчилдөж байгаа тул цаашид хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль журамд нийцүүлэн төлөвлөж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.2 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ-ийг боловсруулж, холбогдох хууль журмын дагуу баталсан байна.

Авто замын тухай хуулийн 14.3-т “нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлууна.” гэсэн заалтын дагуу анх аймгийн ИТХ-ын 2016 оны 12-р сарын 02-ний өдрийн 4/2-р тогтоолоор 2017 онд замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт, зарцуулах төсвийг хэлэлцэж, шинээр гүйцэтгэх 13 ажилд 309,6 сая төгрөг, өмнөх онд дутуу хэрэгжсэн 3 ажилд 36,0 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Тайлант хугацаанд дээрх тогтоолд 3 удаа өөрчлөлт оруулж нийт 25 төсөл арга хэмжээнд 551,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төсвийг баталсан байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга, хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг Сангийн сайд, дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 47/61 тоот тушаалаар батлагдсан журмын 3.3 “Хайгуул, зураг, төсөл, төсвийг **мэргэжлийн байгууллага, хүмүүс тооцож**, аймаг хотын засаг даргаар баталгаажуулна” гэж заасны дагуу “МЦЛ” ХХК нь 12 төсөл арга хэмжээ, “ЦЭСДА” ХХК 1 төсөл арга хэмжээний зураг төсвийг хийж гүйцэтгэсэн байна.


Эрдэнэцогт сумын Ямаан усны даваанаас Хүрэмтийн гүүр хүртэлх хөрсөн замын засварын ажлын төсвийг ХОХБТХ-ийн мэргэжилтэн зохиож, МХГ-ын улсын байцаагч хянасан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн тул холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитаар ИТХ-аар батлагдаагүй төсөл арга хэмжээг урьдчилан гэрээ байгуулан гүйцэтгүүлж дараа нь тодотгол хийж баталсан зөрчил илэрлээ. Тухайлбал:

- *Аймгийн ИТХ-ын 11 дүгээр сарын 27-ны өдрийн 7/01 тоот тогтоолоор “Унадаг дугуйн замын будгийн ажил” батлагдахаас өмнө буюу 2017 оны 09-р сарын 08-ны өдөр 6,1 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Баялаг номгон” ХХК компанитай гэрээ шууд байгуулж, санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг мөрдөлгүй гэрээ байгуулж, санхүүжүүлсэн тул цаашид зөрчлийг гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.*

2.3 Хатуу хучилттай авто замын засвар арчлалтын 39,0 сая төгрөгийн ажлаас бусад төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн нийт 25 төсөл арга хэмжээний зарцуулалтыг бүтцээр харуулбал:



Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх 11 төсөл арга хэмжээнээс 1 ажлыг нээлттэй тендер шалгаруулах аргаар, 10 ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна. Үүнд:



Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын засвар арчлалтын ажил нь аймгийн ИТХ-аар батлагдаагүй байхад уг ажлыг гэрээ байгуулалгүйгээр 7 дугаар сард “Их богд зам” ХХК 39,0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн бөгөөд уг хэрэгжсэн ажлын худалдан авах ажиллагааг 12 дугаар сард зохион байгуулсан нь байна. Энэ нь сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.20-д заасан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу

зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Энэ талаар ХОХБТХ-ийн мэргэжилтэн А.Доржоос тодруулахад бороо их орсны улмаас авто замын эвдрэл маш их гарсан ба 2017 оны зам засварын ажлын төлөвлөгдсөн тоо хэмжээ нэмэгдэж нэмэлт засварын ажлыг “Их богд зам” ХХК хийж гүйцэтгэсэн ба уг ажлын худалдан авах ажиллагааг 12 дугаар сард нөхөж байгуулсан гэсэн тайлбарыг өгсөн.

Дээрх зөрчлийг 2018 оны нийцлийн аудитын төлөвлөгөөнд тусгагдсан Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой хийгдэх аудитаар нарийвчлан шалгах болно.

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны судалгааг нэгтгэн харуулбал:


д/д	Хийгдэх ажлын нэр	ИТХ-ын 2017 оны 11-р сарын 27 өдрийн 7/01-р тогтоолоор баталсан дүн	Үнэлгээн ий хороо байгуулсан огноо	ХАА-ны журам	Тендер зарласан огноо	Оролцсон ААН	Гэрээ байгуулсан ААН	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний хугацаа	Ажлыг хүлээл гэж өгсөн огноо
	1. 2016 ОНЫ ШИЛЖИХ ҮЛДЭГДЭЛ	34,866.2								
1.1	Баянхонгор сумын 1.2.3.4.5.6.7.9 дүгээр багийн нутаг дахь хатуу хучилттай болон хөрсөн замын засвар, хийх ажил	5,666.2					Их богд зам ХХК	6/16/2017	2017/06/16-2017/06/30	7/1/2017
1.2	АЗДТГазарын автозогсоолын үлдэгдэл	-								
1.3	Аймгийн Түйн голын гүүр, Эрдэнэмандал хайрхан,Төв замын гэрэлтүүлгийн үлдэгдэл-Таван орд ХХК	29,200.0								
	2. ШИНЭЭР ЭХЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	516,465.5								
2.1	Албан журмын даатгагчдын холбоонд	42,870.0								
2.2	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замуудад засвар хийх	85,500.0	5/2/2017	НТШ	5/4/2017	1	Их богд зам ХХК	6/19/2017	2017/6/19-2017/7/20	7/16/2017
2.3	Автотээврийн төвийн гаднах зогсоолыг өргөтгөж ачаа тээврийн автомашины талбайг хатуу хучилттай болгох, гэрэлтүүлэг, камертай төвлөрсөн автозогсоолтой болгох	-								
2.4	Автозамын тухай хуулийн 18.5 заалтын дагуу хяналт хэрэгжүүлэх зардал	10,461.1								
2.5	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын арчлалтын ажилд зориулсан тоног төхөөрөмж хэрэгжүүлэх төсөлд	5,771.3					Зэвсэгт хүчний 339-р анги	1/30/2017	2017/02/01-2017/03/31	12/13/2017
2.6	Байдраг кино театрын уулзвараас татварын уулзвар хүртэлх замд хашлага тавих	21,983.0	5/2/2017	ХА	5/12/2017	1	Жаргантай хөх тариа ХХК	5/30/2017	2017/06/02-2017/07/02	7/18/2017
2.7	2.7 дугаар багийн нутаг дэвсгэр дэх хөрсөн замуудад хусалт хийж, шуудуу сэргээх	7,472.0					Их богд зам ХХК	5/23/2017	2017/5/25-2017/6/25	9/30/2017
2.8	Спорт хорооноос 4 замын уулзвар,4 замаас музейн урд уулзвар хүртэлх явган зам хийх	28,535.2	5/2/2017	ХА	5/15/2017	1	Хүрэн жинсний овоо ХХК	6/16/2017	2017/06/18-2017/7/8	8/15/2017
2.9	Эрдэнэцогт сумын Ямаан уснаас сумын урд дэнж хүртэл хайрган хучилттай зам, гүүр засвар хийх	50,000.0		ХА	5/23/2017	1	Цахиур орд ХХК	7/1/2017	2017/7/3-2017/7/17	7/16/2017
2.10	Өлзийт сумын Цагаан хөтлийн цагдаагийн постны цахилгааны төлбөр	3,000.0								
2.11	Хонгор 1000 хорооллын гадна талбайн тохижилт	12,000.0	7/26/2017	ХА	9/20/2017	0	Эх өлзийт богд ХХК	10/12/2017	2017/10/13-2017-10-30	10/18/2017
2.12	Галуут сумын Мандалын гүүрний засвар	-								
2.13	Баянхонгор сумын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт	20,000.0	6/14/2017	ХА	6/16/2017	1	Их богд зам ХХК	7/16/2017	2017/7/16-2017/7/30	дутуу хэрэгжсэн
2.14	Аймгийн төвийн хатуу хучилттай замын цэвэрлэгээ /Давс /	9,000.0					Баянхонгор төмөрт ХХК	1/15/2017	2017/01/16-2017/1/30	1/29/2017
2.15	Ёотон цагааны гадна зам талбайн тохижилт	-								
2.16	Баянхонгор сумын автозамын тэмдэг тэмдэглэгээ	11,841.4	6/14/2017	ХА	6/16/2017	4	Итгэлт тайж ХХК	7/16/2017	2017/7/17-2017/8/17	8/16/2017
2.17	Аймгийн төвийн явган замын засвар	9,789.8								

2.18	Баянхонгор хотын төв зам дагуух гэрэлтүүлэг засварлахад шаардлагатай сэлбэг	8,280.0								
2.19	Эрдэнэцогт сумын Хүрэмтийн модон гүүрний засвар	9,997.8					Баянхонгор төмөрт ХХК	6/14/2017	2017/6/15 - 2017/6/30	7/2/2017
2.20	Эрдэм сургуулийн гадна зам талбайн авто зогсоол	8,000.0	6/14/2017	ХА	6/15/2017	1	Баялаг номгон ХХК	7/16/2017	2017/7/16 - 2017/8/20	огт хэрэгжээгүй
2.21	Төв зам дагуух унадаг дугуйн зам	30,000.0	6/28/2017	ХА	6/28/2017	0	Баялаг номгон ХХК	7/16/2017	2017/7/16 - 2017/8/20	8/26/2017
2.22	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замуудад засвар хийх	39,009.0	12/6/2017	ХА	12/7/2017	0	Их богд зам ХХК	12/14/2017	2017/8/05 - 2017/8/10	7/31/2017
2.23	Төв зам дагуух унадаг дугуйн замын будгийн ажил	6,154.9					Баялаг номгон ХХК	9/8/2017	2017/9/08 - 2017/9/15	9/20/2017
2.24	Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын өвлийн арчлалт хийх / давсны үнэ /	10,000.0					Эх бүрдэн ХХК	12/8/2017	12/18/2017	12/20/2017
2.25	Эрдэнэцогт сумын Хүрэмтийн модон гүүрийг шинэчлэн төмөр бетон гүүр болгох зураг төсвийн үнэ	36,800.0					Хөтөч жим ХХК	12/15/2017	2017/12/15 - 2018/01/26	
2.26	Төв зам, талбайн гэрэлтүүлгийн засвар	50,000.0	11/29/2017	ХА	12/1/2017	1	Биндэр УБН ХХК	12/12/2017	2017/12/13 - 2017/12/28	12/31/2017
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	551,331.7								

3. Сангийн хөрөнгөөр хийгдсэн зарим төсөл арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

3.1 Төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн зарим гүйцэтгэгч гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

➤ Баянхонгор сумын ЗДТГ-ын гаднах 20000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй нийтийн эзэмшлийн зам талбай, явган зам, авто машины зогсоолын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Их богд зам ХХК нь уг ажлыг гүйцэтгэхээр 2017 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөр гэрээ байгуулсан. Аймагт хандиваар “Эм Ай Эл” ХХК-



ийн зураг төслөөр 2,5 км хот доторх хатуу хучилттай авто зам шинээр барих ажлыг “Их богд зам” ХХК хариуцаж гүйцэтгэхэд Баянхонгор сумын ЗДТГ-ын авто зогсоолын ажил хамт хийгдэж хяналтын төсөв хэмнэгдсэн байна. Аудитаар ажлын гүйцэтгэлийг шалгахад 3 байршилд явган зам дутуу тавигдсан ба явган замын дутуу ажлыг гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

➤ Эрдэнэцогт сумын Ямаан усны даваанаас сумын төв хүртэлх 50,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй авто замын засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Цахиур орд ХХК нь уг ажлыг 2017 оны 07 дугаар сарын 03-аас 14 хоног хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2017 оны 07 дугаар сарын 16-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.

Аудитаар “Цахиур орд” ХХК-ийн гүйцэтгэсэн Эрдэнэцогт сумын Ямаан усны даваанаас сумын төв хүртэлх 8 км авто замын засварын ажлыг шалгахад замын тэмдэг, түмбийг дутуу хийсэн, ажлын гүйцэтгэлийг буруу гаргасан ба энэ талаар гүйцэтгэгч компаниас албан ёсоор тодруулга авах гэсэн боловч тайлбар ирүүлээгүй болно. Тус ажлыг баталсан аймгийн ИТХ-ын шийдвэрүүд болон зураг төсөвт тусгагдсан ажлын тоо хэмжээ зөрүүтэй байна. Иймд Эрдэнэцогт сумын

Ямаан уснаас сумын урд дэнж хүртэлх хайрган хучилттай зам засварын ажлын тоо хэмжээ, нэр, төсөв болон гүйцэтгэлийн зөрүүтэй асуудлыг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.



➤ Эрдэм ахлах сургуулийн гаднах

20000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй

800м² зогсоолын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Баялаг номгон” ХХК нь уг ажлыг 2017 оны 07-р сарын 16-аас 2017 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөр хүлээлгэн өгөх байсан ч газрын маргаантай асуудал болон дулааны станцын инженерийн шугамын ажлаас болж хойшлогдсон байна. Энэ талаар дулааны станцын инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэсэн “Сан” ХХК-аас тодруулахад “Марал гүн” ХХК-ны уурын зуухны барилгын газар уг компанийн шугамын трассд орсон байсан тул төлөвлөгөөт хугацаанаас хоцорч угсралтын ажлыг 10 дугаар сарын 25-нд хийж гүйцэтгэсэн гэсэн тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.




Зогсоолын ажлын гүйцэтгэгч “Баялаг номгон” ХХК нь гэрээнд заасны дагуу урьдчилгаанд олгосон 8,0 сая төгрөгөөр ажил хийгээгүй байна. Иймд авто зогсоолын ажлыг 2017 оны 06 дугаар сарын 01-ны дотор чанартай хийж гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

➤ Баянхонгор аймгийн Төв зам дагуух 30,0 сая төгрөгийн өртөгтэй унадаг дугуйн замын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Баялаг номгон ХХК нь уг ажлыг 2017 оны 7 дугаар сарын 16-



ны өдрөөр гэрээ байгуулж 35 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэж, 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.

Аудитаар унадаг дугуйн зам болон будгийн ажлын чанар байдлыг МХГ-ын улсын байцаагчтай хамтран шалгахад зам нь ан цав үүссэн, хашлага суларч гэмтсэн, будаг нь халцарч арилсан зөрчилд гүйцэтгэгчээр баталгаат хугацаанд нь засвар арчлалтыг хийлгэхээр МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гаргууллаа.



➤ Баянхонгор аймгийн төвийн хатуу хучилттай авто замуудад засвар хийх 39900,0 мянган төгрөгийн өртөгтэй 1100м² газар нөхөөс хийх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Их богд зам ХХК нь 2017 оны 07-р сарын 17-оос 14 хоног хийж гүйцэтгэж 2017 оны 12-р сарын 17-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна. Хонгор хотхоны уулзвар дахь замын эвдрэлд жил бүр их хэмжээний хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна.



Иймд тухайн байршил дахь эвдрэл гэмтлийн шалтгааныг судалж, авто замын чиглэлд өөрчлөлт оруулах, засвар арчлалтын ажлын технологийг өөрчлөх талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг өгөв.

Мөн Хот тохижилт үйлчилгээ ОНӨҮГазарт хүлээлгэн өгсөн цас цэвэрлэх тоног төхөөрөмж нь цэргийн ангийн ГАЗ-66 маркын машин дээр суурилж ажиллах учир дангаар нь ашиглах боломжгүй, Хонгор-1000 хорооллын гаднах авто зогсоолыг зардлаар бүртгэсэн нь хөрөнгө эзэнгүйдсэн зэрэг нь сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулжээ.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах ажлууд гэрээнд заасан техникийн шаардлагын дагуу заасан хугацаандаа бүрэн гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн байна.



Баянхонгор аймгийн төвийн хатуу хучилттай авто замуудад засвар хийх 85500,0 мянган төгрөгийн өртөгтэй 1860м² нөхөөс, 1600м ан цав гагнах, хэвтээ

тэмдэглэгээ сэргээх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Их богд зам ХХК нь уг ажлыг 2017 оны 06-р сарын 19-өөс 26 өдөр багтаан гүйцэтгэж, 2017 оны 07-р сарын 16-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.

➤ Модерн клубын уулзвараас Татварын хэлтсийн уулзвар хүртэлх замд хашлага тавих 21983,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 940 м газар хашлага тавих ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Жаргантайн хөх тариа ХХК нь 2017 оны 06 дугаар сарын 10-аас 30 хоног хийж гүйцэтгэж, 2017 оны 07 дугаар сарын 25 нд техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



➤ Баянхонгор аймгийн Уран дөшийн хажуугийн уулзвар, 4 замын уулзвар, музейн урдах уулзвар хүртэлх 28535,2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 800 м урт,



өргөн 2 м явган зам хийх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Хүрэнжинсний овоо ХХК нь уг ажлыг 2017 оны 07 дугаар сарын 01-ээс 45 хоног хийж гүйцэтгэж, 2017 оны 08 дугаар сарын 15-нд техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



➤ Баянхонгор аймгийн Хонгор-1000 хорооллын гаднах 450 м² автомашины зогсоол хийх 12000,0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Эх өлзийт богд ХХК нь уг ажлыг 2017 оны 10 дугаар сарын 13-аас 5 хоног хийж гүйцэтгэж 2017 оны 10 дугаар сарын 23-нд техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



➤ Аймгийн төвийн хатуу хучилттай авто замуудын тэмдэг, тэмдэглэгээг шинээр солих 11841,3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, 20 байршилд 10 төрлийн 82 ширхэг тэмдэг тэмдэглэгээг суурилуулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Итгэлт тайж ХХК нь уг ажлыг 2017 оны 07 дугаар сарын 17-оос 30 хоног хийж гүйцэтгэж, 2017 оны 8 дугаар сарын 18-нд техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



➤ Баянхонгор аймгийн Төв талбайн 49,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гэрэлтүүлгийн засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Биндэр УБН” ХХК нь уг ажлыг 2017 оны 12 дугаар сарын 13-аас 15 хоног хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж 2018 оны 02 дугаар сарын 12-нд техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



Мөн замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэхээр аймгийн ИТХ-аар батлагдсан Өлзийтийн Цагаан хөтлийн цахилгааны төлбөрт 2042,1 мянга, автозамын хяналтын зардалд 10461,1 мянга, Албан журмын даатгалд 33642,1 мянга, Зам арчлалтын тоног төхөөрөмж 5700,0 мянга, 2, 7 дугаар багийн нутаг дэвсгэр дэх хөрсөн замуудад хусалт хийж, шуудуу сэргээх ажилд 7472,0 мянга, Төв замын арчлалт хийх давсны үнэнд 19000,0 мянган төгрөг, аймгийн төвийн явган зам, гэрэлтүүлгийн засварт 18069,8 мянга, Эрдэнэцогт сумын Хүрэмтийн модон гүүрний засвар 9997,8 мянга, Унадаг дугуйн замын будгийн ажилд 6154,9 мянга, Эрдэнэцогт сумын

Хүрэмтийн модон гүүрийг бетон гүүр болгох зураг төсвийн үнэнд 9900,0 мянга, өмнөх оны хөрсөн замын засвар арчлалтын үлдэгдэлд 5666,2 мянга, зураг төсвийн үнэнд 473,6 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна.

3.2. Гүйцэтгэгч байгууллагад гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн олгосон байна.



2017 онд замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 22 төсөл арга хэмжээнд гэрээнд заасны дагуу 429,2 сая, албан журмын даатгагчдын холбоонд 33,6 сая, хяналт хэрэгжүүлэх зардалд 10,5 сая, Өлзийт сумын Цагаан хөтөлийн цагдаагийн постны цахилгааны төлбөрт 2,0 сая, нийт 25 төсөл арга хэмжээнд 475,3 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

3.3. Захиалагч байгууллагын гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажилд тавих шат шатны хяналтын үүргийг Сангийн сайд, дэд бүтцийн сайдын 2000 оны 47/61 тушаалаар батлагдсан журмын 4.5 дахь заалтын дагуу захиалагч талын төлөөлөл, аймгийн ЗДТГ-ын болон сумын ЗДТГ-ын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн, МХГ-ын авто зам, тээвэр хариуцсан улсын байцаагч болон холбогдох эзэмшигч байгууллагын удирдлагууд тухай бүр нь гүйцэтгэж, хэрэгжилтийг хангуулж ажилласан гэх боловч доорх зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Баянхонгор сумын ЗДТГ-ын гаднах явган зам тавих болон Эрдэнэцогт сумын Ямаан уснаас Хүрэмтийн гүүр хүртэлх хөрсөн замын засварын ажил дутуу,
- Баянхонгор аймгийн төв зам дагуух унадаг дугуйн замын ажил чанаргүй,
- Эрдэм ахлах сургуулийн гаднах авто зогсоолын ажил огт хийгдээгүй

зэрэг төсөл арга хэмжээний үр дүн хангалтгүй байгаа нь захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Иймд чанаргүй, дутуу хийгдсэн ажлыг хийж гүйцэтгүүлэх, хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтнуудтай хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.4. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Баянхонгор аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын жагсаалтыг орон нутгийн өмчид бүртгүүлэхээр Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 20-ны 7/1701 тоот албан бичгээр Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж үүний дагуу Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 07 дугаар хурлын тогтоолоор Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын эзэмшигчийг тогтоосон байна.

3.5. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна.

Өмнөх аудитаар 2203,4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5 заалт бүхий зөвлөмж өгөгдсөнөөс төлбөрийн актыг бүрэн барагдуулсан ба зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна.

Заалтын тоо	Өгөгдсөн зөвлөмж	Зөвлөмжийн биелэлт	Хэрэгжилт /хувь/
1	Тендерийн үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн тендерт оролцогчийн чадварын үнэлэх тухай 12 дугаар зүйл болон 14-16 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлж, тендер шалгаруулалт явуулахдаа тендерт материалаа ирүүлсэн компани нь тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зориулалтын тоног төхөөрөмжтэй эсэх, мэргэжлийн ажилчидтай эсэхийг нягтлан, дүгнэлт гаргаж, шалгаруулж байх.	Үнэлгээний хороо нь тендерт оролцогчийн чадварыг үнэлж сонгон шалгаруулсан байна.	100
2	Авто замын санд төвлөрөх авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого болон авто зам ашигласны хураамжийг аймгийн Авто тээврийн газарт бүртгэлтэй автомашины судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж, холбогдох байгууллагуудтай хамтарч төлөвлөсөн орлогыг бүрэн бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Хэрэгжээгүй.	0
3	Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт, төсвийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн батлуулж байх.	Аймгийн ИТХ-ын хуралданаар хэлэлцүүлж батлуулсан байна.	100
4	Замын сангийн хөрөнгийг төлөвлөж зарцуулахдаа урсгал зардлыг санхүүжүүлдэг байдлыг зогсоож, замын хяналтын камертай холбоотой урсгал зардлыг эзэмшигч байгууллагын тайлант жилийн төсөвт баталж, зарцуулж байх	Хэрэгжээгүй.	0
5	ХААН банк, Үйлдвэрчний эвлэл, Анар дэлгүүрийн өмнөх болон 13-р цэцэрлэг, 5-р цэцэрлэг/хуучин төрийн банк/-ийн дэргэдэх автомашины зогсоол, талбайг тухайн албан газар, байгууллагуудад эзэмшүүлж, цаашдын засвар үйлчилгээний ажлыг хариуцуулах талаар эрх бүхий байгууллагад асуудал оруулж шийдвэрлүүлэх.	Зөвлөмжөөр өгөгдсөн байршил дахь авто зогсоол, зам талбайн эзэмшигчийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэрээр тогтоож, арчлалт хамгаалалтыг хариуцуулсан байна.	100
Биелэлтийн хувь			60

АБӨЯХ-ийн татвар болон авто зам ашигласны хураамжаас орох орлогыг төлөвлөхдөө тээврийн хэрэгслийн бодит тоонд уялдуулаагүй ,Өлзийт сумын Цагаан хөтлийн цагдаагийн постны цахилгааны төлбөрт 3000,0 мянган төгрөг

баталж, 2042,1 мянган төгрөгийг зарцуулсан нь АТБӨЯХАТ-ын орлого болон зам ашигласны хураамжийг бодитой төлөвлөж орлогыг бүрэн бүрдүүлэх, Замын сангийн хөрөнгийг урсгал зардалд зарцуулахгүй байх гэсэн зөвлөмжүүд хэрэгжээгүй байна.

Аудитаар нийт 60,0 сая төгрөгийн зөрчил илэрч, 8,0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 52,0 сая төгрөгийн зөвлөмж өгөв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Гүйцэтгэлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Авто замын санд төвлөрөх орлогыг үндэслэлгүй төлөвлөж бүрдүүлжээ.
2. Тээврийн хэрэгслийн бодит тоонд үндэслэж ноогдуулалт хийгээгүй, албан татвар, хураамж авах талаар холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүйгээс 245,4 сая төгрөгийн орлого бүрдэх нөөц бололцоог алдсан байна.
3. Төв талбайн гэрэлтүүлгийн засварын ажлаас бусад төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлого, төлөвлөлтийн арга зүй, урт болон дунд хугацааны хөтөлбөрт үндэслэж иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж төлөвлөж, хууль, журмын дагуу баталсан байна.
4. Хатуу хучилттай авто замын засвар арчлалтын 39,0 сая төгрөгийн ажлаас бусад төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.
5. Захиалагч байгууллагын гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс замын сангаар хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.
6. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

2018.05.15

Баянхонгор хот

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар аймгийн ИТХ-ын захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 19.1 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Авто замын сангийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛД

1. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хууль журамд нийцүүлэн төлөвлөж, урсгал зардлыг санхүүжүүлдэг байдлыг зогсоож, Авто замын тухай хуулийн 24.8-д “Авто замын сангийн хөрөнгийг энэ хуулийн 24.3, 24.4, 24.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.” гэсэн заалтыг мөрдөж ажиллах

2. Замын сангийн хөрөнгөөр хийгдсэн Унадаг дугуйн замын будгийн ажил, Хатуу хучилттай авто замын засвар арчлалтын ажлуудыг ИТХ-аар батлагдаагүй байхад хэрэгжүүлсэн. Цаашид Төсвийн тухай хуулийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтын дагуу төсвийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. Хонгор хотхоны уулзвар дахь замын эвдрэлд жил бүр их хэмжээний хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаад дүгнэлт хийн тухайн байршил дахь эвдрэл гэмтлийн шалтгааныг судалж, авто замын чиглэлд өөрчлөлт оруулах, засвар арчлалтын ажлын технологийг өөрчлөх талаар арга хэмжээ авч ажиллах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ